



**МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ ЗҮЙ,
ДОТООД ХЭРГИЙН САЙД**

Засгийн газрын V байр, Б.Ширэндэвийн гудамж 8/4,
Чингэлтэй дүүрэг, Улаанбаатар хот, 15160
Утас/Факс: (976-51) 26 75 33,
Цахим шуудан: info@mojha.gov.mn,
Цахим хуудас: www.mojha.gov.mn

2022.04.04 № 1/1856

танай _____-ны № _____-т

Зөвлөмж хүргүүлэх тухай

Хууль зүй, дотоод хэргийн сайдын эрхлэх асуудлын хүрээний агентлаг, байгууллагуудын 2021 онд хэрэгжүүлсэн үндсэн үйл ажиллагаанд хийсэн үнэлгээ, эрсдэл зэргийг үнэлэн дараах зөвлөмжийг хүргүүлж байна.

Хууль тогтоомж, тогтоол шийдвэрийн хэрэгжилт, Засгийн газрын 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөр, Монгол Улсыг 2021-2025 онд хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэл болон Монгол Улсын 2021-2025 оны хөрөнгө оруулалтын хөтөлбөр, байгууллагын гүйцэтгэлийн төлөвлөгөөний биелэлт зэрэг нийт 10 үзүүлэлтийн дагуу үнэлгээ хийхэд агентлаг, байгууллагын нийт хэрэгжилт дунджаар 95.09 хувь буюу 4.7 гэсэн үнэлгээтэй байна. Засгийн газрын 2020 оны 206 дугаар тогтоолоор баталсан "Бодлогын баримт бичгийн хэрэгжилт болон захиргааны байгууллагын үйл ажиллагаанд хяналт шинжилгээ, үнэлгээ хийх нийтлэг журам"-ын 6.2-т заасан аргачлалын дагуу "Тодорхой үр дүнд хүрсэн" буюу зорилт нь шалгуур үзүүлэлт, зорилтот түвшиндээ бүрэн хүрээгүй, тодорхой үр дүнд гарч эхэлж байгаа, хэрэгжилт, үр дүнг нэмэгдүүлэх шаардлагатай гэж дүгнэлээ.

Удирдлагын зүгээс агентлаг, байгууллагын 2021 оны үнэлгээний дүн, эрсдэлийн үнэлгээний дүнтэй танилцаад дараахь арга хэмжээг эрчимжүүлэн, тодорхой үр дүнд хүрч ажиллахыг анхааруулж байна. Үүнд:

1.Хууль зүй, дотоод хэргийн сайдын эрхлэх асуудлын хүрээний харьяа агентлаг, байгууллагуудын 2021 оны эрсдэлийн үнэлгээний тайланг нэгтгэхэд учирч болзошгүй онцлог эрсдэлүүдийг бодитой тодорхойлж үнэн зөв бүртгэх, эрсдэлийн төвшинг тодорхой тогтоох зэрэг нь жигдрэх төлөвтэй харагдаж байгаа ч эрсдэлийн ач холбогдлын зэрэглэлийн дагуу арга хэмжээ авах, үр дүнд хяналт шинжилгээ хийх, эрсдэлээ тооцож өмнөх жилүүдтэй харьцуулж хянах үйл ажиллагаа хангалттай бус байна.

Агентлаг, байгууллагад учирч болох эрсдэлийг чанарын зэрэглэлээс нь хамааруулан удирдаж хянах, нэн шаардлагатай буюу өргөн хүрээнд удирдан зохион байгуулах шаардлагатай дараах эрсдэлүүдийг бодлогын төвшинд авч үзэх нь зүйтэй.

Цаашид:

■ Эрсдэлийн үнэлгээний дүгнэлтээс харахад Тооцоо судалгаанд үндэслэн төсвийн төсөл боловсруулан Сангийн яаманд хүргүүлдэг боловч батлагддаггүй, хасагдах, төсөв, хөрөнгө дутсанаас зарим ажил, арга хэмжээ тасалдах, байгууллагын хэвийн үйл ажиллагаанд доголдол үүсэх, алба хаагчийн үүрэг гүйцэтгэлийн чадавх, хөгжилд сөргөөр нөлөөлөх;

■ Эрчим хүчний эх үүсвэр болон холбогдох техник хэрэгсэл, тоноглолууд элэгдэлд эвдрэх;

- Орон тоо, цалингийн сан хангалтгүйгээс иргэдэд үзүүлэх үйлчилгээний хүртээмжтэй байдал алдагдах, алба хаагчдын ажлын ачаалал нэмэгдэх, байгууллагын хэвийн үйл ажиллагаанд доголдол үүсэх, алба хаагчийн хараат бус, бие даан шийдвэр гаргах үйл ажиллагаанд хөндлөнгөөс нөлөөлөх;

- Архивын байрны багтаамж хүрэлцэхгүй, стандартын шаардлага хангахгүйгээс архивын баримт материалын хадгалалт хамгаалалтын горим алдагдаж, устах, гэмтэх;

- Серверийн тоног төхөөрөмжүүдэд иж бүрэн шинэчлэл хийх, программ хангамжийг хөгжүүлэхгүйгээс үйл ажиллагаа доголдох эрсдэл үүсэх.

2. Авлигатай тэмцэх газраас Авлигын эсрэг хуулийн 18 дугаар зүйлийн 18.1.7-д заасны дагуу "Төрийн үйлчилгээ авсан иргэд, байгууллагын судалгаанд тулгуурлан төрийн байгууллагын шударга байдлын түвшинд АТГ-аас жил тутамд хийгдэж буй үнэлгээгээр агентлаг, байгууллагуудыг үнэлдэг. Сүүлийн 2 жилийг харьцуулахад үнэлгээний дүн 4,3%-иар буурсан үзүүлэлттэй байна.

Судалгаанд оролцогчдоос Монгол Улсын авлигын шалтгааныг тодруулахад цалин орлого бага, хувь хүний ёс зүйгүй, хэм, хэмжээгүй байдал, ядуурал, эдийн засгийн тогтворгүй байдал, хүнд суртал, албан тушаал эрх мэдлээ урвуулан ашигладаг байдал зэрэг хариултууд өндөр хувийг эзэлж байна. Харин 10 оролцогч тутмын 2 нь энэ талаар хэлж мэдэхүй байна гэж хариулсан судалгаа байна.

ЗГ-ын агентлагуудын Шударга байдлын үнэлгээ ерөнхий дүнгээрээ 2019 онтой харьцуулахад 1.3 пунктээр буурсан үзүүлэлт гарсан байна.

Иймд Төрийн байгууллагыг авлигаас ангид байлгах, урьдчилан сэргийлэх, авлига үүсэх шалтгаан нөхцөлийг арилгах чиглэлд хэрэгжүүлж буй үйл ажиллагааны нэг хэлбэр нь Шударга байдлын үнэлгээний судалгаа юм. Судалгааны үр дүнд үндэслэн авлигын шалтгаан нөхцөлийг илрүүлэн тэдгээрийг арилгахад чиглэгдсэн үйл ажиллагааг хэрэгжүүлэх нь зүйтэй байна.

Цаашид: Агентлаг, байгууллагууд нь байгууллагын ил тод байдлыг хууль тогтоомжид заасны дагуу үнэн зөв мэдээлж 2022 оны Шударга байдлын түвшний үнэлгээг ахиулан ажиллах нь зүйтэй.

3. Байгууллагын үйл ажиллагааны үнэлгээнд цаашид анхаарах асуудлууд.

- Байгууллагын төлөвлөгөөнд туссан боловч тухайн жилдээ бүрэн биелээгүй буюу 0-50% хувьтай арга хэмжээнүүдийг ойрын хугацаанд нарийвчлан төлөвлөж хэрэгжүүлэх;

- Монгол Улсын Засгийн газрын 2020 оны 216, 217, 218 дугаар тогтоолоор шинэчлэн батлагдсан журам, загвар, аргачлалын дагуу байгууллагын стратеги төлөвлөгөө, жилийн төлөвлөгөөг төлөвлөн тайлагнах;

- Засгийн газрын 2020 оны 206 дугаар тогтоолоор батлагдсан журамд нийцүүлэн хяналт шинжилгээ, үнэлгээг хийх;

- Хууль тогтоомж, тогтоол шийдвэрийн хэрэгжилтийн зорилт арга хэмжээ тус бүрийн хүрэх үр дүн шалгуур үзүүлэлтийн биелэлтийг зохион байгуулж байгаа нэгж тухайн жилд хүрсэн түвшин, зарцуулсан хөрөнгийн хэмжээтэй нь тайлагнаж хэвших. Бодит шалтгааны улмаас хэрэгжих боломжгүй, цаг хугацааны хувьд ач холбогдолгүй болсон шийдвэрийн заалтыг хүчингүй болгох, хяналтаас хасах тухай саналыг жилийн эцсийн тайланд ирүүлж хэвших;

- Монгол Улсын Засгийн газрын 2020 оны 206 дугаар тогтоолоор батлагдсан "Бодлогын баримт бичгийн хэрэгжилт болон захиргааны байгууллагын үйл ажиллагаанд

хяналт-шинжилгээ, үнэлгээ хийх нийтлэг журам"-ын 9 хавсралтад дурдагдсан өөрийн байгууллагад хамаарах заалтуудад хамаарах мэдээллүүдийг цахим хуудсанд байршуулах;

- Яамнаас зохион байгуулагдах хяналт шинжилгээ, үнэлгээ, дотоод аудитын сургалтанд байгууллагын хяналт шинжилгээ, үнэлгээ, аудитын чиглэлээр ажиллаж буй мэргэжилтнүүдийг бүрэн хамруулах;

- Мэдээллийн ил тод байдал ба мэдээлэл авах эрхийн тухай хуулийн хэрэгжилтийг хангаж Их сургуулийн цахим сайт болон мэдээллийн самбарт Их сургуулийн үйл ажиллагааны болон хүний нөөцийн талаарх хуульд заасан мэдээллийг тогтмол байршуулж хэвших;

- Цахим хичээлийн агуулга, суралцагчид хүргэх арга барилыг сайжруулж онлайн программ хангамжийн хэрэглээг нэмэгдүүлэх;

Зөвлөмжийн хэрэгжилтийг ханган ажиллаж биелэлтийг 2022 оны 6 дугаар сарын 20-ны дотор Хяналт шинжилгээ, үнэлгээ, дотоод аудитын газарт ирүүлнэ үү.

Холбогдох утас; 260096, ХШУДАГ-ын Ахлах шинжээч Ц.Нугармаа



Х.НЯМБААТАР

Хууль зүй, дотоод хэргийн яамны
2022 оны 04 дугаар сарын 21-ний өдрийн
11.185% тоот албан бичгийн хавсралт



БАЙГУУЛЛАГУУД

д/д	Шалгуур үзүүлэлт	ДХИ С	ХЗТТ	ХЗҮХ	ШШҮХ	ТТАХНЭ
1.	Хууль тогтоомж, тогтоол шийдвэрийн хэрэгжилт	97	100	100	100	99,2
2.	ЗГ-ын үйл ажиллагааны хөтөлбөрийн хэрэгжилт	100	90	90	96	99,5
3.	Монгол Улсыг 2021-2025 онд хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэл болон Монгол Улсын 2021-2025 оны хөрөнгө оруулалтын хөтөлбөр	-	100	-	95.8	-
4.	Эдийн засаг, нийгмийн хөгжлийн үзүүлэлтийн үнэлгээ	-	100	-	100	-
	Нэгдсэн дүн	59.1	58,5	57	58,7	59,6
1.	Байгууллагын тухайн жилийн үйл ажиллагааны төлөвлөгөөний биелэлт	95,4	95	96,82	98,6	90,8
2.	Төрийн албан хаагчийн сургалт, ажиллах нөхцөл, нийгмийн баталгааг хангах хөтөлбөр	96,6	99,7	97,2	98,8	85,9
	Нэгдсэн дүн	19,2	19,4	19,4	19,5	17,6
1.	Байгууллагын ил тод байдлын үнэлгээ	100	100	99	100	89.1
2.	Шилэн дансны хэрэгжилт	87,2	74,3	98,3	100	99.7
3.	Байгууллагын шударга байдлын түвшний үнэлгээ	-	-	-	-	-
4.	Хэрэглэгчийн үнэлгээ	91	98	96,9	99,1	95,4
	Нэгдсэн дүн	18,5	18,1	19,6	19,9	18.9
Ерөнхий үнэлгээ		96,8	96	96	98,1	96.1
		II	IV	IV	I	III
		2021 онд 96,6% буюу өмнөх оноос 3 хувиар өссөн үзүүлэлттэй байна.				